

**ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД
ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2021 оны 3 сарын 27

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгон, төрөөс баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн 2020 оны жилийн эцсийн биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого /төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын дунд хугацааны стратеги/ 79.3 хувьтай хэрэгжиж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын дагуу салбарт хэрэгжиж буй төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг 2020 оны байдлаар гаргуулан авч үнэлгээг хийв.

3.2. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт.

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоолоор Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг баталсан. Тус бодлогыг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 2015-2020 онд/ I үе шат/, 2020-2025 он /II үе шат/, 2025-2030 он /III үе шат/-уудад хэрэгжих ба Засгийн газрын 2015 оны 396 дугаар тогтоолоор “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги” /2015-2020/-ийг баталсан байна.

Тус бодлогыг үндсэн хэрэгжүүлэгч байгууллага нь Аж үйлдвэрийн яам /хуучнаар/ байсан бөгөөд яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай Засгийн газрын 2016 оны 3 дугаар тогтоолын дагуу хөнгөн үйлдвэрийн асуудал нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, хүнд аж үйлдвэрийн асуудал нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд зарим бусад асуудал нь Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хамаарч байна.

**ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ЯВЦ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**

/2020 оны жилийн эцсийн байдлаар/

Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
		100	90	70	50	30	
1. Аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх;	13	2	3	8		-	79.2
2. Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон "Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал"-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн	3	-	1	2			76.7

нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах;						
3. Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх;;	6		1	4	1	70.0
4. Аж үйлдвэрийн салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих;;	5	1	-	3	1	72.0
5. Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих;	4	-	1	3		75.0
6. Бүтээлч аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;	2	2				100.0
7. Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	5	1	3	1		88.0
8. Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчныг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх.	6		1	5		73.3
Дүн	44	6	10	25	2	79.3

Дунд хугацааны стратегид тусгагдсан ХХААХҮ-ийн салбарт хамаарах 44 арга хэмжээний хэрэгжилт, бодлогын зорилтуудын 2020 оны жилийн эцсийн үр дүн 79.3 хувиар үнэлэгдэж байна.

Аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, бодлогыг хэрэгжүүлэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2018 оны А-79/А/93 дугаар тушаалаар “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан байна. Уг төлөвлөгөө батлагдсанаар толгойлон хэрэгжүүлэх арга хэмжээнүүд тодорхой болсоны үр дүнд төлөвлөгдсөн зарим ажлууд эрчимжсэн байна.

Дөрөв. Дүгнэлт.

1. Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг хүчингүй болсон тул эрх зүйн орчныг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, тандан судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Хуулийн үзэл баримтлалыг боловсруулахаар ажиллаж байна. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр, “Ноолуур” хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд: Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь өмнөх оны түвшинд, арьс ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин өмнөх оноос 2.5 хувиар, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 3.2 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Харин “Худалдааны тухай хууль”-ийг боловсруулж, батлуулах ажилд тодорхой ахиц гараагүй байна.

2. Монголын Ноос Ноолуурын Холбооны дэргэд “Баталгаажуулалтын албыг байгуулсан. Тус алба нь олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан тул үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй МУ-ын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий байгууллага бий болсон. Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан экспортод гаргаж эхэлсэн.

3. ХХААХҮС-ын 2020 оны 11 дүгээр тушаалаар 1643 малчин, 16 ЭМАА эрхлэгчдэд үйлдвэрт тушаасан сүүний урамшуулалд 766.7 сая төгрөг олгов. Ингэснээр хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн сүүний үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх оноос 30.6 хувиар нэмэгдсэн байна.

4. “Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлүүдийг тогтоон, үйлдвэрийг кластераар хөгжүүлэх стратегийг боловсруулан, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор нь төлөвлөн

хэрэгжүүлэх зорилт"-ыг хэрэгжүүлэх хүрээнд тус онд орон нутагт малчид, хоршоодыг Малчид, хоршоодтой хамтран ажилласнаар: Малчид малын эрүүл мэнд, чанар болон үүлдэрт анхаарч эхэлсэн. Түүхий эдийн чанарт ахиц гарсан, хогт хольц буурсан, малчдын орлого нэмэгдсэн. Түүхий эдийг нас болон өнгөөр ангилан ялгаж нийлүүлдэг болсон. Малчид, хоршоод зориулалтын уутанд түүхий эдийг савладаг болсноор хорогдол багасч, тээвэрлэхэд хялбар болсон. Малчид түүхий эдээ үйлдвэрлэгчид шууд нийлүүлснээр дундын зуучлагч нарыг шахаж ашгаа өөрсдөө хүртэх болсон. Кластерын зарчмаар: Өгөөж шим ХХК-Анхан шатны боловсруулалтыг хийж, Сноу филдс ХХК-ээрмэлийн утас үйлдвэрлэн, Жинст Мөрөн ХХК, Мөнхбумууд ХХК, Сноу филдс ХХК нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортод гаргаж байна.

5. Харин хөнгөн аж үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын ажил санхүү, хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдэхгүйгээс ажлын явц удаашралтай байна. Аж үйлдвэрийн тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Тав. Санал, зөвлөмж.

1. Хөнгөн аж үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, улсын төсөв болон “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах арга хэмжээг авах,
2. Аж үйлдвэрийн тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээг бүрдүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх,
3. Үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлж буй эхлэлийг улам өргөжүүлж, энэ чиглэлээр тодорхой бүтээлч арга хэмжээг авах, кластераар ажиллаж байгаа үйлдвэрүүдийг сурталчлах.
4. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн хугацаа дууссан тул дахин шинээр боловсруулж. Батлуулах

Бодлогын баримт бичгийн 2020 оны хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

**ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН
ХАВСРАЛТ**

2020 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, ҮР дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1	4.1.1. Аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх;	4.2.1.1. Аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратеги, төлөвлөгөө, зорилтот хөтөлбөрүүдийг олон улсын хөгжлийн жишигт нийцүүлэн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагатай уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх;	2015 - 2020	улсын төсөв-10.0 сая төг		Хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Хөнгөн үйлдвэрлэлийн тухай" хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна. Тандан судалгааны зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэсэн. Хуулийн үзэл баримтлалыг боловсруулах ажил хийгдэж байна.	70%
2		4.2.1.2. Оюуны өмчийн эрхээр хамгаалагдсан үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулахыг бодлогоор дэмжих;	2015 - 2020			Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн хүрээнд оОлон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий “Баталгаажуулалтын алба”-ыг байгуулсан. Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдгээр баталгаажуулан экспортонд гаргаж эхэлсэн. - "ISO 9001-2015 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо” стандартыг Мон-Ирээдүй” ХХК арьс шир боловсруулах үйлдвэр, “Бест Шүес” ХХК гутлын үйлдвэр, Дархан Нэхий ХК нэхий, арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээг олгосон. - Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлагад тавигдах шаардлагын тухай олон улсын ISO 16128 стандарт, ОУ-ын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрүүллээ.	90%

3		4.2.1.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд хамруулах тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх;	2015 2020	-	-		Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээнд Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан 155 нэр төрлийн барааны жагсаалтыг Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлуулсан. 2019 онд 450 тэрбум төг худалдан авалтыг хийсэн. 2020 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд хамруулах зорилгоор "Төрийн худалдан авалт" үзэсгэлэн худалдааг ЗГХЭГ, яамд, аймаг, нийслэлийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж эхэлсэн боловч цар тахлын улмаас хойшлогдсон болно.	70%
4		4.2.1.4. Худалдааны эрх зүйн орчныг дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, хөгжүүлэх бодлоготой уялдуулан, нэг хаалганы тогтолцоог хөгжүүлж, тарифын болон тарифын бус зохицуулалтыг олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэх;	2015 2020	-	-		Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Өргөн хэрэглээний бараа болох гурил, будаа, малын тэжээл, хивэг, өвсийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хүнсний бүх төрлийн будаа, ургамлын тос, малын гаралтай өвс тэжээлийг Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хуулийн төслийг хэлэлцэхийг олонхийн саналаар дэмжиж, анхны хэлэлцүүлэгт шилжүүлж, УИХ-ийн хуралдаанаар батлуулсан.	100%
5		4.2.1.5. Үйлдвэрлэл эрхлэгчдэд татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	2015 2020	-	-		Хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Хөнгөн үйлдвэрлэлийн тухай" хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна. Монгол Улсын хэмжээнд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүх төрлийн будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, элсэн чихэр, ургамлын тосыг болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтийг хүндрэлгүй давахад шаардагдах өвс, бүх төрлийн малын тэжээл, тэжээлийн үр, хүнсний улаан буудай, улаанбуудайн үр, тослог ургамлын тосыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.	70%

6		4.2.1.6. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг бий болгож, тогтолцоог боловсронгуй болгох;	2015 2020	-	-	Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг бий болгож, тогтолцоог боловсронгуй болгох хүрээнд 2019 онд “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 87 дугаар тогтоол болон “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг батлуулж, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагааг сайжруулах эрхзүйн орчин сайжирсан. Жижиг дунд үйлдвэрлэлийн сангаар дамжуулан олгосон зээлийн эргэн төлөлт муу байгаатай холбоотойгоор сангийн үйл ажиллагааг эхний ээлжид сайжруулах, сангаас улсын төсөвт төлөх хугацаа хэтэрсэн өр, төлбөрийг бууруулж, цаашид гадаадын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл, АХБ-ны Хөдөө, аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл, Япон Улсын Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслүүдийг ХХААХҮЯ, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагаатай уялдаатай явуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч байна. Эдгээр төслүүдийн хүрээнд оролцогч банкаар дамжуулан хөнгөлөлттэй хүүтэй, урт хугацаатай зээл олгох, бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд экспортлоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авсан. Зээлийн батлан даалтын санд зөвхөн Засгийн газраас хөрөнгө оруулсны зэрэгцээ, АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр тус санг бэхжүүлэх төсөл хэрэгжиж байгаатай холбоотой төрийн байгуулсан Зээлийн батлан даалтын сангийн гаргасан батлан даалтад өөр Засгийн газрын тусгай сангаас давхар батлан даалт гаргах шаардлагагүй тул холбогдох хуулийн өөрчлөлтийг 2019 онд УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан.	70%
7		4.2.1.7. Зээлийн батлан даалт болон хөрөнгийн барьцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх;	2015 2020	-	ЗБДС- 35,600.0 сая.төг	Зээлийн батлан даалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, эрчимжүүлэх зорилгоор банкууд болон банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар нэг зээлдэгчид олгох батлан даалтын хэмжээг нэмэгдүүлэх болон бусад тулгамдаж буй асуудлыг зохицуулах зорилгоор хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 12 дугаар сайрын 23ны өдрийн А-395 тоот тушаалаар батлуулан ажиллаж байна. Зээлийн батлан даалтын сан 2020 оны 12 дугаар сарын 15 ны байдлаар 63 зээлдэгчид 12,0 тэрбум төгрөгийн батлан даалт, 23,6 тэрбум төгрөгийн зээл гаргаад байна.	90%

8		4.2.1.8. Кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бий болгох;	2015 - 2020	-	-	<p>Дархан үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бий болгох ажлын хүрээнд: 1. "Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" ЗГ-ын 2020 оны 178 дугаар тогтоолыг батлуулав. "Дархан арьс ширний цогцолбор"-ын хэрэгжүүлэгчид "Тэрээ байгуулах эрх олгох тухай" 2020.05.15-ны өдрийн Сайдын А-185 тушаалыг батлуулав. "Дархан арьс ширний цогцолбор" ОНӨХХК-тай 200515/07/165 дугаар бүхий Бодлогын гэрээг 2020.05.15-ны өдөр байгуулав. Улсын төсвөөс гаргах санхүүжилтийг хөрөнгө оруулалтаар тооцох боломжтой эсэх болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах боломжийн талаар судалж "Төрийн өмчит компани байгуулах тухай" ЗГ-ын 2020 оны 185 дугаар тогтоолыг батлуулав. "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлах тухай ЗГ-ын 2020.12.23-нд 233 дугаар тогтоолыг батлуулсан. Ноос, ноолуурын үйлдвэрүүд хамтран кластерын зарчмаар ажиллаж, бүтээгдэхүүнээ эьспортод гаргаж эхэлсэн байна. Тухайлбал: "Жинст мөрөн" ХХК-ний Хөвсгөл аймагт бэлтгэсэн ноолуурыг "Өгөөж шим" ХХК ангилан ялгах, угаах, самнах зэрэг анхан шатны боловсруулалтыг хийж, "Сноу филдс" ХХК нь 22/2, 26/2 номерын ээрмэл утсыг үйлдвэрлэж улмаар 28/2 номерын ээрмэл ноолууран утас үйлдвэрлэхээр ажиллаж байна. Энэхүү ээрмэл утсаар "Жинст мөрөн" ХХК, "Мөнхбумууд" ХХК, "Сноу филдс" ХХК-ууд сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоод, гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулж байна.</p>	90%
---	--	--	-------------	---	---	---	-----

9		<p>4.2.1.9. Аж үйлдвэрийн салбарт шаардлагатай судалгаа хөгжлийн ажлыг эрчимжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ төрлийг бий болгох, технологийн түвшинг сайжруулах, аж үйлдвэрийн оюуны өмчийн патентийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан судалгааны тогтолцоог бүрдүүлэх, судалгааны төвийг байгуулж ажиллуулах;</p>	2015 - 2020	Гадаадын төсөл, хөтөлбөр-127.6 сая.төг	<p>Салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ, дэвшилтэт болон өндөр технологи нэвтрүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, импортыг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хог хаягдал, дахин боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилтууд тавьсан. Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд арьс шир, ноос ноолуурын салбарын техник технологийн хүрсэн түвшинг тогтоох, тулгарч буй асуудал, гарц шийдэл, R&D судалгаа хөгжүүлэлт, инновац дамжуулалтын чиглэлийг тодорхойлох, дотоод ба гадаад хамтын ажиллагааг уялдуулан өргөжүүлэх ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төвийг Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 93 дугаар тогтоолоор байгуулсан. “Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (SECiMC2)” төслийн хүрээнд “Сүлжмэлийн гүйцэтгэн боловсруулалтын инкубатор” сургалтын төвийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн дээр байгуулж чадавхыг сайжруулав. Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн шугамаар Монголын ноос, ноолуурын холбооны дэргэд баталгаажуулалтын алба байгуулсан. Тус “Баталгаажуулалтын алба” нь олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан тул үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй Монгол Улсын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий байгууллага болсон. Мөн тус төслийн хүрээнд Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн “Нэхмэлийн гүйцэтгэн боловсруулалтын сургалтын материаллаг бааз тоног төхөөрөмж бүхий төв” байгуулан чадавхыг сайжруулав.</p>	100%
---	--	---	-------------	--	---	------

10		4.2.1.10. Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан аж үйлдвэрийн мэдээллийн сан бүхий мэдээллийн системийг бий болгох;	2015 2020	-	-	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулах үйлдвэрийн байршлын тойм зургийг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн мэдээллийн санд Монгол улсын газрын зураг дээр online хэлбэрээр цахим хаяг: https://geoportal.nsd.gov.mn байрлуулсан. Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн нэгдсэн сан болох www.industry4.nda.gov.mn цахим системд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх ажилд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажилласан. Тус мэдээллийн систем олон нийтэд нээлттэй бөгөөд Оюу Толгой ХК үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж тус цахим системд бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн сангийн системийг Үндэсний хөгжлийн газрын МОН ТА-9371:“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төсөл”-ийн системтэй холбож хөгжүүлэлтийг хийсэн. 2020 онд ХХААХҮЯ-наас "Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарын үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх, үйлдвэрлэл төрөлжүүлэх судалгаа", "Улсын хэмжээний мод, модон түүхий эдийн бэлтгэлийн цогц судалгаа", "Гоо сайхны бүтээгдэхүүний түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, экспортлох чиглэлийн судалгаа"-ны ажлуудыг мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн. Дээрх судалгааны ажлуудын үр дүнд оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбар, мод модон бүтээгдэхүүн, тавилга үйлдвэрлэлийн салбар, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын мэдээллийн санг шинээр болон шинэчлэн бүрдүүлсэн.	70%
11		4.2.1.11. Дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг бий болгох;	2015 2020	-	-	1. ХХААХҮЯ-аас Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийг 2020-2021 онд боловсруулан УИХ-д өргөн барихаар төлөвлөн ажиллаж байна. Тус хуулийн төсөлд дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг тусгуулахаар ажиллаж байна. 2. “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-г хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр Эко парк байгуулах, хаягдал шилийг дахин боловсруулах чиглэлээр холбогдох ажлыг тусгуулан батлуулсан. 2. БОАЖЯ-наас боловсруулсан "Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр"-т дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээнүүдийг төлөвлөн тусгуулсан.	70%

12	4.2.1.12. Генетик материал, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэдгээрийг ашигласнаас бий болох үр ашгийг ил тод хуваарилахтай холбоотой эрх зүйн орчныг бий болгох;	2015 - 2020	-	-	Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 82 дугаар тогтоолоор батлагдсан Малын генетик нөөцийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх, түгээн дэлгэрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх асуудлыг тусгаж хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Мал аж ахуй эрхэлж ирсэн олон зуун жилийн уламжлалт мэдлэгийг түгээх, сурталчлах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран "Малчин өрх бүр үйлдвэрлэгч", "Малчин өрхөд үйлдвэрлэх сүү, цагаан идээ" зэрэг малчдад зориулсан гарын авлагыг 2400 ширхгийг хэвлэн орон нутагт хүргүүлж, нийтийн хүртээл болгов. "Малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх үйл ажиллагааны аргачлал"-ын төслийг боловсруулж, бүх шатны нээлттэй хэлэлцүүлгийг явуулж, ХХААХҮЯ-ны вэб сайтад байршуулан олон нийтээс санал авч эцэслэн боловсруулав. Аргачлалын төслийг Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлэн, саналыг тусгаж ХХААХҮ-ийн сайдын тушаалын төсөлд санал авч байна.	70%
13	4.2.1.13. Аж үйлдвэрийн салбарт мэдээллийн технологи, харилцаа холбоо болон мэдээллийн үйлчилгээг нэвтрүүлж, аж үйлдвэрийн салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.	2015 - 2020	-	-	Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн нэгдсэн сан болох www.industry4.nda.gov.mn цахим системд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэж нийт Монгол Улсын хэмжээнд 3600 орчим аж ахуйн нэгжийн мэдээллийн сан бий болоод байна. Тус нэгдсэн мэдээллийн сангаар дамжуулан үйлдвэрлэл эрхлэгчид хоорондоо уялдаа холбоотой ажиллах, төрийн бодлого боловсруулахад судалгааны суурь бааз болох юм.	70%
Зорилт 1-ийн дүн						79.20%

14	4.1.2. Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлон "Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал"-ыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой	4.2.2.1. Экосистем, геополитик, хүн амын нутагшил, суурьшил, дэд бүтэц, ашигт малтмал, үндсэн түүхий эдийн нөөцөд үндэслэн аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг тодорхойлох;	2015 - 2020		Түүхий эдийн нөөцөд үндэслэн хөнгөн үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэх зорилгоор кластер хэлбэрээр ажиллах цогцолбор, үйлдвэрүүдийг байгуулах ажлыг эхлүүлээд байна. Баруун бүс нутагт малын гаралтай түүхий эдийг боловсруулах "Шинэ ховд" үйлдвэр технологийн паркийг байгуулж байгаа бөгөөд дэд бүтцийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Тус ажлын хүрээнд жилдээ 3 сая ш арьс, 3 мянган тонн ноос, 300 тонн ноолуур, 3400 тоо хаягдал яс, 440,0 мянган гогцоо өлөн гэдэс боловсруулах Баруун аймгуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварыг бий болгох дэвшилтэт техник технологи бүхий 16-18 үйлдвэр баригдана. Дархан-Уул аймагт төвийн бүсийн түүхий эдийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор жилдээ 10 сая ширхэг арьс, 10 мян.тн ноос, 1.0 мян.тн ноолуур боловсруулах "Дархан арьс ширний цогцолбор"-ыг байгуулж байна. Тус цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалт 22.9%-тай байна. Хөвсгөл аймагт ойн нөөцөд тулгуурлан модны цогцолбор үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэн, холбогдох ТЭЗҮ судалгаа, тооцоог батлуулан, дэд бүтцийн ажлыг эхлүүлээд байна. 2020 онд ХХААХҮЯ-наас Үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг тогтоон, дэд бүтцийн байршил, эдийн засгийн үр өгөөжийн судалгааг гүйцэтгэсэн.	70%
15	уялдуулан боловсруулах;	4.2.2.2. “Монгол Улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг боловсруулж, батлуулах;	2015 - 2020		ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1 -д Монгол улсын Үйлдвэржилтийн газрын зургийг эко систем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан гаргах. гэсний дагуу Үйлдвэржилт-21:100” үндэсний хөтөлбөрт шинээр байгуулах үйлдвэрүүдийн байршлыг нөөц, зах зээлтэй нь уялдуулан хүчин чадлыг тогтоож, үйлдвэржилтийн зураглал гаргав. Аймгуудын үйлдвэржилтийн өнөөгийн байдлын зургийг гаргаж, улсын хэмжээнд 16 салбарын нийт 30 гаруй сэдэвчилсэн зургуудын эхийг бэлтгэж, хэвлэмэл болон цахим хэлбэрээр хийж гүйцэтгэсэн. Хүнд үйлдвэрлэлийн бүсийг үндэслэн Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх орон зайн горим, зургийг боловсруулсан. Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах ажлын хүрээнд “Үйлдвэржилтийн хөгжил, байршлын бодлогын судалгаа”-ны ажлыг Үндэсний хөгжлийн газар хийж гүйцэтгэсэн. Уг судалгаагаар үйлдвэрүүдийн байршил, хүчин чадлыг тогтоосон. Мөн Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн нэгдсэн сангийн цахим системээр дамжуулан үйлдвэрүүдийн байршил, хүчин чадал, төрөл орон сайн мэдээллийг авах боломжоор хангагдаад байна.	90%

16		4.2.2.3. Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлж, нэгдсэн мэдээллийн санг бий болгох.	2015 2020	-	-	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай хамтран "Үйлдвэржилт 21:100" үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулах үйлдвэрийн байршлын тойм зургийг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн мэдээллийн санд Монгол улсын газрын зураг дээр online хэлбэрээр цахим хаяг: https://geoportal.nsvdi.gov.mn байрлуулсан. Аж үйлдвэрийн салбарын мэдээллийн нэгдсэн сан болох www.industry4.nda.gov.mn цахим системд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх ажилд дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажилласан. Тус мэдээллийн систем олон нийтэд нээлттэй бөгөөд Оюу Толгой ХК үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж тус цахим системд бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн сангийн системийг Үндэсний хөгжлийн газрын МОН ТА-9371:“Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх төсөл”-ийн системтэй холбож хөгжүүлэлтийг хийсэн. 2020 онд ХХААХҮЯ-наас "Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбарын үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх, үйлдвэрлэл төрөлжүүлэх судалгаа", "Улсын хэмжээний мод, модон түүхий эдийн бэлтгэлийн цогц судалгаа", "Гоо сайхны бүтээгдэхүүний түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, экспортлох чиглэлийн судалгаа"-ны ажлуудыг мэргэжлийн холбоод, судалгааны байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн. Дээрх судалгааны ажлуудын үр дүнд оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбар, мод модон бүтээгдэхүүн, тавилга үйлдвэрлэлийн салбар, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын мэдээллийн санг шинээр болон шинэчлэн бүрдүүлсэн.	70%
Зорилт 2-ын дүн						76.70%	

17	4.1.3. Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх;	4.2.3.1. Бүс нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоох;	2015 - 2020			Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн 36 дугаар тогтоолоор “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг батлуулсан. ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 129 дүгээр тогтоолоор “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус хөтөлбөрөөр 21 аймаг болон Улаанбаатар хотод 100 үйлдвэр байгуулан хөгжүүлэхээр тусгагдсан. Түүхий эдийн нөөцөд үндэслэн хөнгөн үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэх зорилгоор кластер хэлбэрээр ажиллах цогцолбор, үйлдвэрүүдийг байгуулах ажлыг эхлүүлээд байна. Баруун бүс нутагт малын гаралтай түүхий эдийг боловсруулах "Шинэ ховд" үйлдвэр технологийн паркийг байгуулж байгаа бөгөөд дэд бүтцийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Тус ажлын хүрээнд жилдээ 3 сая ш арьс, 3 мянган тонн ноос, 300 тонн ноолуур, 3400 тоо хаягдал яс, 440,0 мянган гогцоо өлөн гэдэс боловсруулах Баруун аймгуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадварыг бий болгох дэвшилтэт техник технологи бүхий 16-18 үйлдвэр баригдана. Дархан-Уул аймагт төвийн бүсийн түүхий эдийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор жилдээ 10 сая ширхэг арьс, 10 мян.тн ноос, 1.0 мян.тн ноолуур боловсруулах "Дархан арьс ширний цогцолбор"-ыг байгуулж байна. Тус цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалт 22.9%-тай байна. Хөвсгөл аймагт ойн нөөцөд тулгуурлан модны цогцолбор үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэн, холбогдох ТЭЗҮ судалгаа, тооцоог батлуулан, дэд бүтцийн ажлыг эхлүүлээд байна. 2020 онд ХХААХҮЯ-наас Үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг тогтоон, дэд бүтцийн байршил, эдийн засгийн үр өгөөжийн судалгааг гүйцэтгэсэн.	70%
18		4.2.3.2. Хүнд, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх, кластерийн талаар баримтлах стратегийг боловсруулах;	2015 - 2020			Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэх кластерын тэргүүлэх чиглэлийг тогтоох ажлын хүрээнд 2020 онд улсын хэмжээнд судалгааг хийж тэргүүлэх чиглэлийг саналыг боловсруулан Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар бэлдэж байна.	50%

19		4.2.3.3. Хөдөө аж ахуй, уул уурхайн түүхий эдийг дотооддоо бүрэн боловсруулах үйлдвэрлэлийг үе шаттайгаар хөгжүүлэх;	2015 2020	-	-	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бүрэн боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор Дархан-Уул аймагт жилдээ 10 сая ширхэг арьс, 10 мян.тн ноос, 1.0 мян.тн ноолуур боловсруулах "Дархан арьс ширний цогцолбор"-ыг байгуулж байна. Тус цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалт 22.9%-тай байна. Дэд бүтцийн бүтээн байгуулалтад 165.8 тэрбум төгрөгийн 14 ажил хийж гүйцэтгэхээс 40.9 тэрбум төгрөгийн 5 бүтээн байгуулалтын ажил хийгдэж, 121.1 тэрбум төгрөгийн 9 бүтээн байгуулалтын ажил хүлээгдэж байна. Годруулбал: Төслийн бэлтгэл 100%, Арьс ширний үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжын барилга 63.4%, тоног төхөөрөмж 30.9%, Цахилгаан түгээх, хангах дэд бүтэц 57.2%, гадна инженерийн шугам сүлжээ /дулааны шугам, цэвэр ус/ 77.4%-тай байна. Үйлдвэрийн бүтээн байгуулалтад 392.6 тэрбум төгрөгийн 17 үйлдвэр байгуулагдахаас 10.8 тэрбум төгрөгийн ноос боловсруулах 1, богийн арьс боловсруулах 1 үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж, 348.6 тэрбум төгрөгийн 13 үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил хүлээгдэж байна. Бог малын арьс боловсруулах үйлдвэр 8.1%, ноос ноолуур боловсруулах үйлдвэр 31.9%, нийт үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт 1.4%-тай байна.	70%
20		4.2.3.4. Түүхий эд бэлтгэн нийлүүлэх тогтолцоо, бараа бүтээгдэхүүнийг борлуулах тээвэр логистикийн сүлжээг кластерийн тогтолцоотой уялдуулан хөгжүүлэх;	2015 2020	-	-	Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журмыг шинэчлэн боловсруулж ЗГ-ын 343-р тогтоолоор батлуулав. Угаасан ноолуурын экспортыг бууруулах, ноолуурын боловсруулалтын түвшинг ахиулах бодлогын хүрээнд “Ямааны ноолуурын үйлдвэрлэл худалдаанд мөрдөх” техникийн зохицуулалтын төслийг боловсруулж, холбогдох тооцоо, судалгааг хийж, холбогдох яамдаас санал авахаар хүргүүлсэн. Уг техникийн зохицуулалт батлагдсанаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх юм. Үндэсний үйлдвэрүүдийн түүхий эд бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах зорилгоор 2020 онд ХБ-ны эх үүсвэрээр 44 аж ахуйн нэгжид 103,9 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээл олгосон. ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжааг идэвхжүүлэх, зах зээлийн нэгдсэн дэд бүтцийг сайжруулах зорилгоор Төв аймгийн Аргалант сум Эмээлт орчимд ХАА-н биржийн ложистикийн төв байгуулж, хүлээж авахад бэлэн болсон. Биржийн итгэмжлэгдсэн 54 хоршооны бараа, түүхий эдийн судалгааг гаргасан. Малчид, малчдын хоршоодтой хамтран зөв ангилан бэлтгэсэн түүхий эдээ Хөвсгөл аймгийн Мөрөн суманд байрлах Жинст мөрөн ХХК-ийн үйлдвэрийн түүхий эдийн нэгдсэн агуулахад хүлээн авч хаягжуулан Улаанбаатар хотруу тээвэрлэдэг. Уг түүхий эдийг Өгөөж шим ХХК, Сноу филдс ХХК, Мөнхбумууд ХХК нь хамтран кластерын зарчмаар	90%

						ажиллаж, эцсийн бүтээгдхүүнээ Герман улсад нээсэн нэрийн дэлгүүрээр борлуулж эхэлсэн.	
21		4.2.3.5. Кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийг эдийн засгийн тооцоо, үр өгөөжид үндэслэн дэд бүтцийн хамт цогцоор барих байршил, жагсаалтыг баталж, хэрэгжүүлэх;	2015 2020	-	-	УИХ-ын 2003 оны "Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл батлах" тухай 54 дүгээр тогтоолын дагуу үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар Улаанбаатар хотод Эмээлт, Налайх, Багануурын үйлдвэрлэл, технологийн парк, хөдөө орон нутагт Дархан, Ховд, Сүхбаатар, Эрдэнэт хотуудад үйлдвэрлэл, технологийн парк байгуулахаар ажиллаж байна.	70%
22		4.2.3.6. Газрын тос, нүүрс хими, кокс хими, өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэрийг дагалдах үйлдвэрийн хамт цогцоор нь байгуулах.	2015 2020	-	-	Уг арга хэмжээ нь УУХҮЯ-нд хамаарна.	70%
						Зорилт 3-ын дүн	70%
23	4.1.4. Аж үйлдвэрийн салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр	4.2.4.1. Аж үйлдвэрийн салбарт үзүүлэх санхүү, хөрөнгө оруулалтын тогтолцоог боловсронгуй болгох;	2015 2020	-	109,000.0 сая төг	УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоол, ЗГ-ын 101 дүгээр тогтоолын дагуу ноолуур бэлтгэлийн зээлд хамрагдсан 44 аж ахуйн нэгжийн 103.9 тэрбум төгрөгийн зээлийн 2020 оны зээлийн хүүгийн хөнгөлөлт 5.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн.	100%

24	ашигтай хамтын ажиллагааг дэмжих;	4.2.4.2. Инноваци, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, дахин боловсруулах болон бүтээлч аж үйлдвэрлэлийг тусгай сангаас дэмжих;	2015 - 2020	-	-	"ISO 9001-2015 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо" стандартыг Мон-Ирээдүй" ХХК арьс шир боловсруулах үйлдвэр, "Бест Шүес" ХХК гутлын үйлдвэр, Дархан Нэхий ХК нэхий, арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээг 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр ХХААХҮЯ-нд гардуулав. - Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлагад тавигдах шаардлагын тухай олон улсын ISO 16128 стандарт, ОУ-ын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрүүллээ. - Олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын "Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт"-ыг явуулах эрх бүхий "Баталгаажуулалтын алба"-ыг байгуулсан. Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ "Монголын Хаан ширхэгт" чанарын тэмдгээр баталгаажуулан экспортод гаргаж эхэлсэн.	70%
----	-----------------------------------	---	-------------	---	---	--	-----

25		4.2.4.3. Аж үйлдвэрийг дэмжих тусгай сангийн хөрөнгийг дотоод, гадаад эх үүсвэрээр нэмэгдүүлэх;	2015 2020	- -	<p>2019 онд “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 87 дугаар тогтоол болон “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг батлуулж, ЖДҮХС-ийн үйл ажиллагааг сайжруулах эрхзүйн орчин сайжирсан. Сангаар дамжуулан олгосон зээлийн эргэн төлөлт муу байгаатай холбоотойгоор сангийн үйл ажиллагааг эхний ээлжинд сайжруулах, сангаас улсын төсөвт төлөх хугацаа хэтэрсэн өр, төлбөрийг бууруулж, цаашид гадаадын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Дэлхийн банкны Экспортыг дэмжих төсөл, АХБ-ны Хөдөө, аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл, Япон Улсын Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслүүдийг ХХААХҮЯ, ЖДҮХС-ийн үйл ажиллагаатай уялдаатай явуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Эдгээр төслүүдийн хүрээнд оролцогч банкаар дамжуулан хөнгөлөлттэй хүүтэй, урт хугацаатай зээл олгох, бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд экспортлоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авсан. Зээлийн батлан даалтын санд зөвхөн Засгийн газраас хөрөнгө оруулсны зэрэгцээ, АХБ-ны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр тус санг бэхжүүлэх төсөл хэрэгжиж байгаатай холбоотой төрийн байгуулсан Зээлийн батлан даалтын сангийн гаргасан батлан даалтад өөр Засгийн газрын тусгай сангаас давхар батлан даалт гаргах шаардлагагүй тул холбогдох хуулийн өөрчлөлтийг 2019 онд УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан. "Үйлдвэрлэлийг дэмжих тухай" хууль 2019 онд хүчингүй болсноор үйлдвэржилтийг дэмжих тусгай санг татан буулгасан. 2020-2021 онд Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийг боловсруулан батлуулахаар холбогдох судалгааг хийлгэж байна. Тус хуулинд хөнгөн үйлдвэрийг дэмжих тусгай сан, сангийн хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг тусган хууль эрхзүйн орчинг бүрдүүлэхээр төлөвлөж байна.</p>	70%
----	--	---	--------------	--------	--	-----

26	4.2.4.4. Кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркард үйлдвэрлэл эрхлэгчдийг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих;	2015 2020	-	-	Дархан үйлдвэрлэл, технологийн паркийг хөгжүүлэх эрх зүйн таатай орчныг бий болгох ажлын хүрээнд: 1. "Мал аж ахуйн түүхий эдийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" ЗГ-ын 2020 оны 178 дугаар тогтоолыг батлуулав. "Дархан арьс ширний цогцолбор"-ын хэрэгжүүлэгчид "Тэрээ байгуулах эрх олгох тухай" 2020.05.15-ны өдрийн Сайдын А-185 тушаалыг батлуулав. "Дархан арьс ширний цогцолбор" ОНӨХХК-тай 200515/07/165 дугаар бүхий Бодлогын гэрээг 2020.05.15-ны өдөр байгуулав. Улсын төсвөөс гаргах санхүүжилтийг хөрөнгө оруулалтаар тооцох боломжтой эсэх болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах боломжийн талаар судалж "Төрийн өмчит компани байгуулах тухай" ЗГ-ын 2020 оны 185 дугаар тогтоолыг батлуулсан. "Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлах тухай ЗГ-ын 2020 оны 233 дугаар тогтоолыг батлуулсан. 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг тус тус үндэслэн "Жагсаалт батлах тухай" ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.	50%
27	4.2.4.5. Хүнд аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийг төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, концессоор барьж байгуулах, хөрөнгө оруулалтыг татвар, санхүүгийн бодлогоор дэмжих.	2015 2020	-	-	УУХҮЯ-нд хамаарна.	70%
Зорилт 4-ийн дүн						72%

28	4.1.5. Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин	4.2.5.1. Аж үйлдвэрийн салбарт судалгаа хөгжлийн ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр төрөөс урамшуулах зохицуулалтыг бий болгох;	2015 2020	-	-		Төрөөс 2020-2024 онд хөнгөн үйлдвэрлэлийг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилгоор Салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ, дэвшилтэт болон өндөр технологийг нэвтрүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, импортыг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хог хаягдал, дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилтууд тавьсан. Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд бидэнд арьс шир, ноос ноолуурын салбарын техник технологийн хүрсэн түвшинг тогтоох, тулгарч буй асуудал, гарц шийдэл, R&D судалгаа хөгжүүлэлт, инновац дамжуулалтын чиглэлийг тодорхойлох, дотоод ба гадаад хамтын ажиллагааг уялдуулан өргөжүүлэх ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төвийг Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 93 дугаар тогтоолоор байгуулсан.	70%
29	боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн бодлогоор дэмжих;	4.2.5.2. Аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжих, гадаад улс орнуудын технологийн дэвшлийг ашиглах, нутагшуулах замаар болон өөрийн орны нөөц, чадавх, онцлогт тулгуурлан хөгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлийг тодорхойлж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх;	2015 2020	-	-		Европын холбооны Трам төсөлтэй хамтран сарлагийн хөөвөр боловсруулах чиглэлээр загвар төсөл хэрэгжүүлж байна. Жинст мөрөн, Сноу филдс, Мөнхбумууд, Бест кашемир, Уужин, Сор кашемир зэрэг үйлдвэрүүд кластерын зарчмаар ажиллах загварыг хэрэгжүүлж эхлээд байна.	70%

30		4.2.5.3. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх тогтолцоог бүрдүүлэх;	2015 2020	-	-	1. Эрдэм шинжилгээний байгууллагын чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд Хөнгөн аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг чадавхжуулж олон улсын туршлагыг нэвтрүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой сургалтын төвүүдийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн Армоно корпораци болон Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнг түшиглэн байгуулав. Засгийн газрын 2019 оны 370 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2020 оны Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 232, 233 дугаар тогтоолоор “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” ТӨААТҮГ-ын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, захиралыг батлав. 2. "Текстилийн гүйцэтгэн боловсруулалт"-ын инкубатор төвийг ХҮСХХүрээлэнд байгуулав. Ингэснээр сүлжмэл бүтээгдэхүүний гүйцэтгэн боловсруулалтын багц хөтөлбөр: сурах бичиг, цахим сургалт, стандарт ажиллагааны зааварчилгаа, тоног төхөөрөмж, сургагч багш нар хөнгөн үйлдвэрийн салбарынхандаа мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд бэлэн боллоо. 3. "Аж үйлдвэрлэлийн ирээдүй" сургалтын төвийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа туршилт, үйлдвэрлэл бизнесийн корпораци дээр байгуулав.	90%
----	--	---	--------------	---	---	---	-----

31		4.2.5.4. Төр, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн дэвшилтэт технологи, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх тогтолцоог дэмжих.	2015 - 2020		<p>ХХААХҮЯ-ны захиалгаар, ШУТС-ийн санжүүжилтээр 2019 оноос ХААИС-ийн бүрэлдэхүүн сургууль болон харьяа 4 ЭШХ-нд Шинжлэх ухаан, технологийн 7 төсөл, ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургууль түүний харьяа Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнд 1 төсөл хэрэгжиж эхэлсэн. Дээрх шинжлэх ухаан, технологийн 8 төслийг хэрэгжүүлэхэд Шинжлэх ухаан, технологийн сангаас нийт 813.3 сая төгрөгийн санхүүжилт хийгдэх бөгөөд захиалагч, санхүүжүүлэгч, гүйцэтгэгч нар 3 талт гэрээ байгуулан ажиллаж байна. "Бөсгөсөн шохой - инновацийн бүтээгдэхүүн" судалгааны ажлыг хийж MNS 6738:2018 стандартын гидратын шохой гарган авсан нь арьс ширний салбарт нэвтэрч эхлээд байна. Ингэснээр үйлдвэрүүдийн урьдчилан цэвэрлэх байгууламжид нийлүүлэх лагийн хэмжээ багасч байна. Урьдчилан цэвэрлэх байгууламжийн бохир ус саармагжиж, лагийн үнэр дарагдах зэрэг үр дүнгүүд гарч байна. Өндөр технологи болон инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох гарааны бизнесийг бойжуулах, хүний нөөцийг чадавхжуулах, сургалт, семинар, үзэсгэлэн, хурал семинар болон бусад арга хэмжээг зохион байгуулах, инновацын соёлыг дэлгэрүүлэх, инновацыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Улаанбаатар инновацын төв”-д оюутан, залуус, энтрепрёнер, бизнес эрхлэгч, эрдэмтэн судлаач залуучууд болох 361 иргэнийг гишүүнээр элсүүлж, инкубаторт 16 гарааны компани бойжуулан зөвлөх 6 үйлчилгээ үзүүлж, сургалт, семинар, олон нийтийг хамарсан арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Туршлага судлах цуврал арга хэмжээ, коммюнити гишүүд өөрийн санаагаа танилцуулж ажиллаж буй төслийн багтаа гишүүн элсүүлэх, мэдээллийн технологийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүд нэг дор цуглаж салбарынхаа ололт, амжилт, туршлага солилцох тогтмол уулзалт зэрэг инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэх 85 эвент арга хэмжээ зохион байгуулагдаж нийт танхимаар 2170, онлайнаар 25118 гаруй иргэнийг тус тус хамруулсан.</p>	70%
Зорилт 5-ын дүн					75%	

32	4.1.6. Бүтээлч аж үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;	4.2.6.1. Үндэсний түүх, өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, мэдлэг, мэдээлэлд суурилсан бүтээлч аж үйлдвэрлэлийн салбарыг дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурлан мэдлэгийн менежментийг хэрэгжүүлэх замаар хөгжүүлж, шинэ чадавхи, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох;	2015 2020	-	-		Монголын соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх хүрээнд ХХААХҮЯ-ны Хөнгөн үйлдвэрийн газраас монгол үндэсний хувцасны өдөрлөг, бүтээлч ажлын аяныг зохион байгуулав. Уг арга хэмжээний үеэр нийт ажилтан албан хаагчдын дунд “Дээлээрээ гоёцгооё” 7 хоног зохиож, мөн дээлээ өөрөө урлаж өмсдөг иргэнийг шалгаруулах, Шик салонтой хамтран загварын дээлний чиг хандлагын талаар лекц танилцуулга хийсэн. Үндэсний монгол дээлний өдөртэй болох тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан, яамдаас санал авч нэгтгэн хуралдаанаар оруулахад бэлэн болгосон. Монгол дээлийг инновацийн бүтээгдэхүүн болгож буй “Хадлан” дээлийн загварыг сурталчлан танилцуулж, гадаад зах зээлд үйлдвэрлэн гаргаж байна. Монгол уламжлалт гэрийн ерөнхий архитекторыг орчин үеийн майхан хэлбэрт оруулан инновацийн бүтээгдэхүүн болгон, гадаад зах зээл дээр хөрөнгө оруулах маркетинг хийж, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж буй ГЭР ТЕНД ХХК экспортын үйлдвэрлэл явуулж, гадаад орны захиалга авч үйлдвэрлэж байна.	100%
33		4.2.6.2. Соёлын статистикийг олон улсын байгууллагаас баталсан аргачлалын дагуу нэвтрүүлэх.	2015 2020	-	-		2020 онд Үндэсний Статистикийн Хорооны даргын А/36 тоот тушаалаар албан ёсны статистикийн 27 маягт, БСШУСЯ-ны сайдын А/181 тоот тушаалаар захиргааны статистикийн мэдээллийн 12, бүртгэлийн мэдээллийн 11 маягт, нөхөх зааврыг тус тус шинэчлэн баталсан.	100%
Зорилт 6-ын дүн								100%
34	4.1.7. Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	4.2.7.1. Үйлдвэрийн удирдлага, инженер, техникийн ажилтныг өндөр технологи бүхий улсуудад үе шаттайгаар бэлтгэх, мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх тогтолцоог бий болгож, дотоодод бэлтгэх чадавхыг сайжруулах;	2015 2020	-	-		МННХ, Шима Сейки компанийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Японы Шима Сейки сүлжмэлийн бүрэн автомат машинаар үйлдвэрлэлээ явуулдаг компаниудын удирдлагуудыг Шима Сейки компанитай танилцуулах аялыг зохион байгуулж, Шима Сейки дизайн системийн сургалт, танилцуулгыг хийв. Нийт 25 хүн оролцсон. АХБ-ны санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн Сорилтын төвийн итгэмжлэгдсэн лабораторид Японы JEOL фирмийн SEM багаж суурилуулж, тоног төхөөрөмжийг нийлүүлэгч талаас ХҮСХХ-ийн шинжээчдийг уг багаж дээр ажиллах чадвар эзэмшүүлэх сургалтыг явуулсан. Монголын радиогийн “Үйлдвэржилтийн цаг” хөтөлбөр болон Монголын үндэсний телевизийн “Өглөөний зочин” зэрэг нэвтрүүлгээр ноолуурын салбарын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны онцлог, ололт амжилт болон хөтөлбөр, түүний хэрэгжилтийн явцын талаар олон нийтэд сурталчлах ажлыг хийсэн. Мөн фэйсбүүк, болон ХХААХҮЯ-ны вэбсайтад цаг үеийн мэдээллүүдийг оруулж, олон нийтэд мэдээлэх ажлыг хийж байна	70%

35		4.2.7.2. Техникийн болон технологийн боловсролын чиглэл, төрлөөр мэргэжлийн зэрэг олгох, мэргэжлийн ур чадвартай уялдсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх;	2015 2020	-	-	1. Хөнгөн үйлдвэрийн салбарын ажилтнуудад мэргэжлийн зэрэг олгох, мэргэжлийн ур чадвартай уялдсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог сайжруулах эрх зүйн орчин бий болгох хүрээнд “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж хүргүүлсэн. Тодруулбал, ХНХЯ, ШУТИС-ын Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн эрдэмтэн судлаачид, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдийн 30 гаруй төлөөллийг хамруулан санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. 2. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: МННХ, Шима Сейки компанийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Японы Шима Сейки сүлжмэлийн бүрэн автомат машинаар үйлдвэрлэлээ явуулдаг компаниудын төлөөллийг Шима Сейки дизайн системийн сургалтанд хамруулав. Нийт 15 хүн оролцсон. -Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн Сорилтын төвийн итгэмжлэгдсэн лабораторид Японы JEOL фирмийн SEM багаж суурилуулж, тоног төхөөрөмжийг нийлүүлэгч талаас ХҮСХХ-ийн шинжээчдийг уг багаж дээр ажиллах чадвар эзэмшүүлэх сургалтыг явуулсан. -ХБНГУ-д арьс шир, ноолуурын үйлдвэрийн 6 инженер сургалтад хамрагдсан. -"Текстилийн салбарын тогтвортой үйлдвэрлэл ба эко-тэмдэг" төслөөс "ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛ" сургалтыг зохион байгуулж 65 ИТА хамрагдсан.	90%
36		4.2.7.3. Гадаадад ажиллаж, амьдарч байгаад ирсэн иргэдийн үйлдвэрлэл эрхлэх бүтээлч санал, санаачлагыг дэмжих, тэдний мэдлэг, туршлагыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;	2015 2020	-	-	БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Тувагийн БНУ, ИБУИВУ-ын Лондон хотноо ажиллаж амьдарч байсан залуучуудын санаачилсан "Бахархал үндэсний бренд" дэлгүүрийг нээхэд ХХААХҮЯ-наас мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн. Үндэсний уламжлалт хувцасны соёлыг түгээх зорилгоор "Сэцэн бренд" хөгжүүлэн ажиллаж байгаа "Сэцэн фэшн" ХХК -ний үйл ажиллагааг дэмжиж, хөнгөн үйлдвэрийн салбарын бараа бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин арга хэмжээнүүдэд хамруулан хамтран ажиллаж байна. “Бүтээлч Монгол 2020” үзэсгэлэн худалдааг 2020 оны 07-р сарын 3-наас 10-ны өдрүүдэд Мишээл Экспо олон улсын үзэсгэлэн худалдааны төвд хамтран зохион байгуулсан ба арга хэмжээний хүрээнд гадаадад ажиллаж амьдарч байгаад ирсэн иргэд эзэмшсэн мэргэжил, шинэ технологи, ноу хаугаа хуваалцах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ сурталчлах зэрэг ажлууд хийгдлээ.	90%

37		4.2.7.4. Үйлдвэрлэл, технологийн инкубаторийг хөгжүүлэх замаар гарааны компаниудын үйл ажиллагааг дэмжих;	2015 - 2020	50 сая төг		Ховд аймгийн ХХААГ, ХХҮГ-аас "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих" үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулж "Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд өрнөж буй тус үйл ажиллагаанд Ховд аймгийн 80 гаруй залуу үеийнхэн оролцож, 60 гаруй шинэ гарааны бизнес төслөө танилцууллаа. 2020 онд 13 шинэ, шилдэг гарааны бизнес төсөл шалгаруулж, тус бүр 10 сая буюу нийт 130 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөсөн. Үүнээс энэ удаагийн үйл ажиллагаагаар дамжуулан таван шинэ гарааны бизнесийг шалгаруулж, дэмжин ажиллалаа.	90%
38		4.2.7.5. Ур чадварт суурилсан, ажлын байран дахь болон зайны сургалтаар мэргэжилтэй ажилчдыг сургаж, бэлтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.	2015 - 2020	-		Ур чадварт суурилсан, ажлын байран дахь болон зайны сургалтаар мэргэжилтэй ажилчдыг сургаж, бэлтгэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд: -Хүүхдийн гутлын масс үйлдвэрлэлийн ажлын байрны сургалтыг сонгогдсон 1 үйлдвэр дээр 5 сарын хугацаанд явуулсан. Сургалтад сонгогдсон байгууллагын бүх ажилтан, албан хаагчдыг хамруулав. Онол, практик хосолсон сургалтын үр дүнд бүтээгдэхүүний чанар, технологийн дамжлага, хөдөлмөрийн бүтээмж, материал ашиглалт дээшилж ажилчдын ур чадвар сайжирсан. -“Гутлын зохион бүтээлт” ур чадвар сайжруулах, мэргэшүүлэх сургалтыг цахимаар зохион байгуулж ЭМШҮИС, ШҮТИС-ын эрдэмтэн багш нар сургалт хийж хөдөө орон нутаг, Улаанбаатар хотоос 90 гаруй хүнийг хамруулж, мэргэшүүлэх, ур чадварын шалгалт аван сертификат олгосон. -UNIDO-гийн арьс ширний олон улсын эксперт Висванатан Мурунами “Арьс шир боловсруулах үйлдвэрийн орчин дахь ажлын байрны эмх цэгц ба менежмент”, "LWG Байгаль орчны аудит", "Арьс шир боловсруулах үйлдвэрийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй", "ISO14001 Байгаль орчны менежментийн системийн дотоод аудитор бэлтгэх” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж олон улсын сертификат олгож, салбарын эрдэмтэн судлаачид, инженерүүд, үйлдвэрлэл эрхлэгчид зэрэг 500 гаруй хүнийг хамруулав. - ХҮСХХ-ээс Хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэжлийн чадавхийг сайжруулах зорилгоор “Арьс ширний технологийн шинжээч-лаборант бэлтгэх” чиглэлээр 1, “Нэхмэл, Сүлжмэлийн гүйцэтгэн боловсруулах технологи” сэдэвт 3 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулж мэргэжилтэй ажилчдыг сургаж бэлтгэв.	100%
Зорилт 7-ын дүн							88%

39	4.1.8. Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчныг	4.2.8.1. Хоёр болон олон талт худалдааны харилцаа, бүс нутгийн интеграцид нэгдэн ороходоо дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах;	2015 2020	-	-		Хамааралгүй заалт (Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ОХУ-д хийх албан ёсны айлчлалынхаа хүрээнд Евразийн эдийн засгийн комиссын Сайд нарын зөвлөлийн дарга Т.С.Саркисяны Москва хотноо хүлээн авч уулзсан. Уулзалтаар Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс 2020-2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд гарын үсэг зурсан.)	70%
40	бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх.	4.2.8.2. Худалдааны ерөнхий хэлэлцээр, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээр, чөлөөт худалдааны хэлэлцээр болон давхар татварын гэрээ, хэлэлцээрийг байгуулах замаар олон улсын болон бүс нутгийн худалдааны интеграцид идэвхтэй оролцож, экспортыг нэмэгдүүлэх, дотоодын болон хамтарсан үйлдвэрүүдийг байгуулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, дэвшилтэт техник, технологи, шилдэг менежментийн арга хэрэгслийг нэвтрүүлэх;	2015 2020	-	-		(Хамааралгүй заалт) Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ОХУ-д хийх албан ёсны айлчлалынхаа хүрээнд Евразийн эдийн засгийн комиссын Сайд нарын зөвлөлийн дарга Т.С.Саркисяныг 2019 оны 12 сарын 4-нд Москва хотноо хүлээн авч уулзсан. Уулзалтаар, Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны Ажлын багийн III хуралдаан 2019 оны 10 дугаар сард амжилттай болсныг тэмдэглэж, энэ удаагийн айлчлалын үеэр, Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс 2020-2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд гарын үсэг зурсан. Тус төлөвлөгөөнд Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжүүлэх, тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулах, экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зэрэг ажлуудыг тусгасан. Энэхүү ажлуудыг цаашид хэрэгжүүлснээр Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах нь бодит нөлөө үзүүлэх боломжтой гэж үзэн хамтран судлах Ажлын баг гаргаж, эдийн засгийн үр ашгийг нарийвчлан тооцохоор санал солилцов.	70%
41		4.2.8.3. Түнш орнууд болон бүс нутгийн хэмжээнд байгуулах худалдааны хэлэлцээрт худалдааг хөнгөвчлөх, тарифын болон тарифын бус саад тотгорыг багасгах арга хэмжээг тусгах замаар гадаад зах зээлд дотоодын үйлдвэрийн барааны	2015 2020	-	-		Хамааралгүй. (Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ОХУ-д хийх албан ёсны айлчлалынхаа хүрээнд Евразийн эдийн засгийн комиссын Сайд нарын зөвлөлийн дарга Т.С.Саркисяныг 2019 оны 12 сарын 4-нд Москва хотноо хүлээн авч уулзсан. Уулзалтаар, Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтын ажиллагааны Ажлын багийн III хуралдаан 2019 оны 10 дугаар сард амжилттай болсныг тэмдэглэж, энэ удаагийн айлчлалын үеэр, Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс 2020-2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд гарын үсэг зурсан. Тус төлөвлөгөөнд Евразийн эдийн засгийн холбооны гишүүн орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжүүлэх, тарифын	70%

		нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх;				болон тарифын бус саад тотгорыг бууруулах, экспортын бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зэрэг ажлуудыг тусгасан. Энэхүү ажлуудыг цаашид хэрэгжүүлснээр Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах нь бодит нөлөө үзүүлэх боломжтой гэж үзэн хамтран судлах Ажлын баг гаргаж, эдийн засгийн үр ашгийг нарийвчлан тооцохоор санал солилцов.)	
42		4.2.8.4. Экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг худалдааны болон эдийн засгийн чөлөөт бүсэд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	2015 - 2020			Засгийн газрын 2020.06.12-ний өдрийн хуралдаанаар Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн парк” ХХК, “Зуунмод парк” ХХК-д Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Тус 2 үйлдвэрлэл технологийн парк нь экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Эрдэс плазм ХХК - иас ирүүлсэн хүсэлтийн дагуу шилний үйлдвэрийн парк байгуулах асуудлыг судлан үзэж үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ирүүлэх талаар санал хүргүүлсэн.	70%
43		4.2.8.5. Цахим сүлжээ ашиглан аутсорсингийн үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдах үйл ажиллагааг дотоодод болон олон улсад нэгдсэн зохион байгуулалттайгаар хөгжүүлэх;	2015 - 2020	-	-	Хөдөө аж ахуйн салбарыг бүрэн цахимжуулан мэдээллийн цогц системийг бий болгож, мөшгөх тогтолцоог нэвтрүүлж байна. Ингэснээр төрийн үйлчилгээний ил тод, үр ашигтай, хүртээмжтэй байдлыг сайжруулан салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх юм. Хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн нэгдсэн систем бий болсноор "E-MONGOLIA" системийг ашиглан иргэд, аж ахуйн нэгж төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг түргэн шуурхай авах, гарал үүсэл нь тодорхой, эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх, малаа даатгалд хамруулах, урамшуулалд хамрагдах, зээл авах, худалдах хөрөнгийн үнэлгээ хийлгэх, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох, хамтран ашиглах, мэдээллийн давхардал болон зөрүүтэй байдлыг засах юм. Хөдөө аж ахуйн биржийн жишиг ложистикийн төвийг байгуулж, 2021 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Тус ложистикийн төвийн дэргэдэх итгэмжлэгдсэн агуулахад арилжаалсан бараа, түүхий эдийг хадгалах ба ложистикийн систем болон хяналтын системээр дамжуулан биет бүтээгдэхүүнийг арилжина. Мөн Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг өргөжүүлэх, цаашид тариаланчдын үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын баталгааг хангах, төрөөс олгож буй мөнгөн урамшууллыг бүтээгдэхүүний чанар, стандартад нийцүүлэн олгох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 2021 оноос хүнсний улаанбуудайг биржээр арилжаалах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Яамны цахим хуудсанд бүтээгдэхүүн цэс үүсгэн Монголд үйлдвэрлэсэн салбарын брэнд бүтээгдэхүүний танилцуулгыг	70%

						оруулсан. Жил бүр "Монголд үйлдвэрлэв" товхимлыг хэвлүүлж, иргэд, ААН-д сурталчилж байна.	
44	4.1.8. Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчныг бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх.	4.2.8.6. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг хамруулах ажлыг зохион байгуулалтаар хангах.	2015 - 2020	-	-	Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор “Улаанбаатар түншлэл-2020” Олон улсын үзэсгэлэн худалдаа, "Монгол экспорт экспо-2020" дотоодын үзэсгэлэн худалдааг 2020 оны 9, 10 сард тус тус зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд хөнгөн үйлдвэрийн салбарын 218 үйлдвэрлэгчид оролцож, 550 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үзэсгэлэнгээр нийт давхардсан тоогоор 6000 гаруй хүн очиж сонирхон худалдан авалт хийсэн байна. Мөн "Экспорт монгол 2020" Олон улсын цахим форум, сургалт, виртуал үзэсгэлэнг ГХЯ, ҮХГ, Экспорт олон улсын худалдааны төв ТББ-тай хамтран 2020 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан цахим үзэсгэлэн худалдаанд хөнгөн, хүнсний салбарын нийт 43 ААН 200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцсон бөгөөд 10 гаруй орноос давхардсан тоогоор 24000 гаруй удаагийн хандалт хийж, сайтад байршуулсан ААН-ийн материалуудаас 200 гаруй материалыг татаж авсан байна. Нийт арга хэмжээний хүрээнд https://www.exromongolia.org/ хаягаар АНУ, Япон, Австри, ХБНГУ, Франц, ОХУ, БНХАУ, Их Британи, Сингапур, Вьетнам, Болгар, Чех, Польш, БНСУ зэрэг 20 орчим улсын 360 гаруй, дотоодын 1600 гаруй оролцогч бүртгүүлэн оролцсон бөгөөд бусад олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар 6400 гаруй удаагийн хандалт хийсэн байна.	90%
						Зорилт 8-ын дүн	73.3%
						ХШҮ-ний дундаж дүн	79.3%